

ЭКОНОМИКСИЙН ЦАГААН ТОЛГОЙГ ХЭН САЙН МЭДЭХ ВЭ?

УЛСЫН ХVII ОЛИМПИАДЫН ХОЁРДУГААР ШАТ: МАКРО ЭДИЙН ЗАСАГ

2024-05-05

БОДЛОГО №4(10 ОНОО)

Засгийн газар үнийн хяналт тогтоох, татвар, татаас болон бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хуваарилалтыг улс төрийн хүчээ ашиглан шууд зохицуулах замаар шийдэх тохиолдол байдаг.

1. Ингэж шийдэх нь худалдаанаас олох хожоонд хэрхэн нөлөөлдөг вэ? **(3 ОНОО)**
2. Энэ нь бизнес болон хөдөлмөрийн бүлгүүдийн хонжоо хайлтын зэрэг (degree of rent-seeking) болон улс төрчдийн сонгуулийн хандивын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлдөг вэ? **(3 ОНОО)**
3. Энэ төрлийн бодлого нь эдийн засгийн өсөлтийг дэмждэг үү? Яагаад дэмждэг эсвэл дэмждэггүй вэ? **(4 ОНОО)**

Хариулт

Үнийн дээд, доод хязгаар болон заавал дагах/биелүүлэх ёстой бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар гэх мэт зохицуулалтууд нь худалдаанаас олдог хожоог ерөнхийдөө бууруулдаг гэж үздэг. Мөн, үүнээс гадна энэ төрлийн бодлого нь янз бүрийн бүлгүүдийн хонжоо хайх (rent-seeking) үйл ажиллагааг идэвхжүүлэх бөгөөд энэ нь улс төрчдөд өгөх хандивыг нэмэгдүүлдэг. Энэ төрлийн бодлого нь эдийн засгийн өсөлтийг бууруулна учир нь энэ төрлийн бодлого нь үрэлгэн хонжоо хайх үйл ажиллагаа эрхлэх сонирхлыг нэмэгдүүлж, зардалтай нь харьцуулахад илүү нэмүү өртөг шингээсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр бүтээх, үйлдвэрлэх сонирхлыг бууруулдаг.

*Бэлтгэсэн: Эдийн засгийн тэнхимийн дэд профессор,
Доктор С. Дөлбадрах*